

1920-НОД ОНЫ ИЖИЛ МӨРНИЙ САВ ДАГУУХ ӨЛСГӨЛӨН БА ХАЛИМАГУУДЫГ МОНГОЛ УЛСАД НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ГЭСЭН АСУУДЛЫН ТУХАЙ

**(О голоде в Поволжье в 1920-х гг. и вопросе
о переселении калмыков в Монголию)**

**On the Famine in the Volga Region in the 1920s
and on the Issue of the Kalmyk's Resettlement to Mongolia**

Н. Наранжаргал (N. Naranjargal)¹

¹аспирант Калмыцкого государственного университета (Post-graduate Student at Kalmyk State University).
E-mail: naranjargal_85@yahoo.com

1920 он гарсанаар Ижил мөрний сав дагуух нутгуудаар ихээхэн ган, зуд болсоноор тухайн бүс нутагт өлсгөлөнгийн аюул нүүрлэсэн билээ. Халимагийн ард түмэн энэхүү хүнд цаг үед уг гарал, шашин шүтлэг нэгтэй монгол ах дүү нараасаа тусламж гуйхад, Монголын засгийн газар энэ хэрэгт шуурхай арга хэмжээ аван албан хаагчдын цалингаас хоёр удаа хасаж, дээр нь улсын сангаас мөнгө гарган, мөн 1000 шар үхрээр тусласан билээ. Энэхүү тусламжийг аваад Халимагийн ард түмэн өлсгөлөнгийн аюулыг үл гэтлэж чадсанд тэднийг монгол нутагт нүүлгэн авч ирэхээр шийдсэн бөгөөд харамсалтай нь энэхүү үйл хэрэг Зөвлөлт Оросын эрх ашигт харшилж байсан тул бүтээгүй билээ.

Түлхүүр үг: өлсгөлөн, Ижил мөрний сав, нүүлгэн шилжүүлэх, тусламж үзүүлэх.

В статье исследуются вопросы, связанные с голодом в Поволжье в 1920–1922 гг. и попытками переселения в связи с этим калмыков в Монголию. Жестокая засуха 1921 г., а также разрушительные последствия Гражданской войны стали главными причинами массового голода на территориях Поволжья и Южного Урала. Руководство Калмыцкой автономной области, оказавшись в сложной ситуации, направило запрос о помощи к Монголии. Правительство Монголии приняло экстренные меры по оказанию гуманитарной помощи, которая стала существенной поддержкой в преодолении последствий голода. Руководство Монголии также предприняло попытку по переселению калмыков на историческую родину, которое, однако не входило в планы Советской России.

Ключевые слова: голод, Калмыкия, Поволжье, гуманитарная помощь, Монголия, переселение.

In the 1920s, two disastrous droughts and rash happened in the Volga region which led to crop damage and famine. The Kalmyk people were in a difficult situation and had to ask the Mongolian people for help. The Government of Mongolia adopted some emergency measures to provide humanitarian assistance. Firstly, wages of some state employees were reduced; secondly, the Mongolian Government borrowed some funding from the state treasury; and thirdly, several thousand heads of cattle were sent to Kalmykia. Thus, the Kalmyk people got timely help from Mongolia and overcame all the difficulties. The Government of Mongolia decided on possible relocation of the Kalmyks to their historical homeland, but it was not in the plans of the Soviet Union.

Keywords: famine, Kalmykia, the Volga region, humanitarian aid, Mongolia, migration.

1920 оны эхэлснээр Ижил мөрний сав дагуух нутгуудаар ган болсны улмаас ургац алдаж, улмаар тухайн нутагт мал аж ахуй голлон эрхэлж байсан Халимагуудад ган, зуд, өлсгөлөнгийн аюул нүүрлэсэн байна.

Энэхүү хүнд бэрх цаг үед Халимагийн автономит муж дахь зөвлөлийн төлөөлөгч Насуновоос «Халимаг ард түмэн эртнээс монголчуудтай харилцаатай байсан одоо тусгаар улс болсонд баяр хүргэж энэ үйл хэрэгт Халимагууд бас тусласан. Эдүгээ

Халимаг нутагт өлсгөлөн болж хэцүү нөхцөл үүссэн тул туслана уу» гэсэн агуулга бүхий Халимагийн автономит мужийн зөвлөлийн №958 тоот бичгийг Зөвлөлт Орост суух Монголын элчин сайдын яаманд [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 19] 1922 оны эхээр ирүүлсэнд «Халимаг ардын өлсгөлөнд туслах зүйл байгааг тогтоон шийтгэж хариу ирүүлнэ үү» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 2] хэмээн МУ-ын гадаад яаманд мэдэгдсэн.

Тухайн үед Халимагийн автономит мужийн зөвлөлийн дээрхи тусламж хүссэн бичгийг ЗОУ-ын зөвлөл дахь Халимагийн төлөөлөгч Амарсанаагаас №883 тоот бичгээр ЗОУ-с МУ-д суугаа элчин сайд Охитинаар дамжуулан МУ-ын засгийн газарт [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 1], Халимагын автономит мужийн төлөөлөгчдийн дарга Номто Очировоос Ерөнхий сайд Цэрэндоржид №2820 тоот бичгээр [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 5] тус тус ирүүлжээ.

Энэхүү өлсгөлөн нь Халимагийн ардуудад маш хүндээр туссан тул ЗОУ-ын элчин сайд 1922 оны 2 сарын 24-д [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 4] өлсгөлөнгийн хэргийг хэрхэн шийдэж байгаагаа мэдэгдэхийг хүссэн албан бичиг явуулжээ.

Халимагийн тал Монгол улсаас тусламж гуйх ажлыг тухайн үед Монгол ардын армид алба хааж байсан Итрах Вакунаев¹ хариуцуулсан [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 1] ба дараа нь өлсгөлөнд тусламж цуглуулах комисс байгуулагдахад дарга нь Ц.-Д. Номинханов болов.

Энэхүү комиссын ажилд тухайн үед монголд цэргийн алба хааж байсан цэргүүд ихээхэн идэвхитэй оролцсон байна. МАА-ын нэгдүгээр бригадын сургагч торгууд Балданцэрэн² цэргийн алба хааж байгаа 8 сургагчийн хамтаар 1922 оны 2 сарын 7-д Богд хаанд «...гачигдал тохиолдсон ард түмний байдлыг гэгээнээр толидон, үлэмжхэн тусламж хүртээн хайрлаж, тусгайлан Гандан хүрээний олон лам нарт уламжлан зарлиг буулгаж тусламж олгуулахыг чин зүрхний голоос хүснэ...» [МУУТА. Х. 1. Д. 1. ХН. 81] хэмээн өргөх бичиг хүргэсэн бол, мөн цэрэгт алба хааж буй 56 хүн «... олон аймаг хошуудад тусгай ухуулга буюу тушаах бичгүүдийг тараан зарлаж өлсгөлөнд тохиолдосон торгуудын ардуудад туслана уу...» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 39. Х. 2] гэсэн № 8 тоот бичгийг 1922 оны 2 сарын 23-д засгийн газарт хүргүүлэх зэргээр хамтран ажиллаж байв.

МУ-ын засгийн газар Халимагийн өлсгөлөн тохиолдсон ардуудад тусламж хүссэн дээрхи бичгүүдийг хүлээн аваад 1922 оны 3 сарын 23-ны өдрийн засгийн газрын 12-р хурлын 7-р зүйлд хэлэлцээд «... язгуур үндэс нэгтэй өлсгөлөнд тохиолдосон ардад

эрх биш тусламж олговол зохих, ...гагцхүү санхүүгийн зүйл хомс учир олон яам ба албан газруудын албан хаагчдад ухуулан зарлаж хэрхэн тусламж олговол зохихыг нэг мөр шийдэж, тусламжыг цуглуулаад уг цугларсан тусламж дээр засгийн газраас 2000 орос төгрөгийг нэмэн гаргаж олгохоор...» [МУЗГА. ЗГТ. 1922. Х. 4] шийдэн дотоодын зэрэг 5 яам [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 39], ардын намын төв хороонд [МҮТАхМАНБТ. Х. 1. Д. 4. ХН. 172. Х. 19–20] мэдэгдэн явуулсан.

Энэхүү туслах үйлсэд «...Нийслэл хүрээний ажил үйлдвэрийн ба албан хаагчдийн захиргаа 1922 оны 4 сарын 1-ний өдрийн нийтийн хурлынхаа шийдвэрийн дагуу хоёр болон гуравдугаар сарын цалингаасаа ...сар дутам 25 лангаас доош хэрэглэлтэй хүнээс 5 %, 25 лангаас дээш 80 лан хүртэл хэрэглэлтэй хүнээс 10 %, 80 лангаас дээш хэрэглэлтэй хүнээс 15 % аар тооцон хасан» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 38] авч, мөн «Дамбадорж дарга 1922 оны 4 сарын 24-д, ...албан хаагчдийн хоёрдугаар сард авбал зохих цалингаас 10 %-аас 1 %-ийг авч...» [МҮТАхМАНБТ. Х. 4. Д. 1. ХН. 88. Х. 95–96] халимагын ардуудад хүргүүлнэ үү? хэмээн сангийн яаманд мэдэгдэх зэргээр монголын албан хаагчид маш идэвхтэй оролцсон байна.

ЗГ-ын олон яамны бүх албан хаагчдын цалингаас хоёр удаа тусалсан мөнгө бүгд 1932 лан 52 пун хагасыг [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 40], улсын сангаас туслах 1000 лан даацах Орос таван цэнгийн [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 42] төгрөг 2000-ыг [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 41] харьяат комиссын дарга Номинхановт 1922 оны 7-р сард шилжүүлэн өгчээ. Энэхүү тусламжийг цааш хэрхэн шилжүүлэн өгсөнийг эргэн мэдэгдэхийг сангийн яамнаас, ЗОУ дахь элчин сайдад 1922 оны 9 сарын 1-ны өдөр мэдэгдсэн ажээ [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 15].

Монгол улсаас Халимагийн ард түмэнд тусласан тусламжийг хүлээн аваад 1923 оны 6 сарын 26-ны өдөр Халимагийн автономит мужийн ерөнхий хурлын газар [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 54], ерөнхий хурлын дарга [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 52] нараас «...Монгол улсаас тусламж болгон илгээсэн алтаар 220 рубль, 50 копейкыг хүлээн авч туйлын их баярласан бөгөөд дахин тусламж үзүүлвэл татгалзахгүй бөгөөд боломжтой бол дахин тусламж үзүүлнэ гэдэгт найдаж байгааг

¹ Х. Б. Кануковын нууц нэр.

² Х. Б. Кануковын нууц нэр.

МУ-ын ЗГ-т мэдэгдэнэ үү...» гэсэн № 3654 тоот бичгийг Москва дахь элчин сайдын яаманд илгээсэн. Энэ тухай 1923 оны 8 сарын 30-ны өдөр Москва дахь элчингээс Монголын гадаад хэргийн яаманд № 128 тоот бичгээр [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 53] мэдэгдэн ирснийг Гадаад хэргийн яам хянан үзээд мөн өдөртөө ардын засгийн газарт «...манай засгийн газраас Халимагийн өлсгөлөнд тусласан алтан төгрөг 220, мөнгө 50 пун хүлээн авлаа гэсэн нь ноднин жил 7-р сард Номинхановт хүлээлгэн өгсөн 2000 рублей, 1932 лан 52 бум хагас мөнгөнөөс зөрж байгаа тул хэрхэн шийдэх бэ...» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 56] гэсэн бичгийг илгээсэн байна.

Засгийн газраас чиглэл өгсөний дагуу 1924 оны 2 сарын 13-ны өдөр Гадаад яамнаас Сангийн яаманд хандуулан «...Халимагийн өлсгөлөнд тусласан мөнгө зөрж байгаа тул үүнийг яаралтай ЗОУ-д суугаа элчин сайдад цахилгаанаар мэдэгдэн, ...хэдий хэрийн, ямар ямар мөнгийг хэдний өдөр авсныг цаасаар гаргуулан нарийвчлан тогтоон эргэн мэдэгдэнэ үү...» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 43] гээд энэ хэргийг Сангийн яаманд [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 44] шийдвэрлүүлэхээр өгсөн байна.

Москва дахь элчин сайдын яамнаас 1923 оны 9 сарын 27-ны өдөр Халимагийн төлөөлөгч Насуновт «МУ-ын ЗГ-аас Халимагийн өлсгөлөнд тусласан мөнгө дутаж байгаа тул энэ хэргийг харьяат ерөнхий хурлын газарт уламжлан тусламжийн мөнгө яагаад зөрөх болсныг мэдэгдэнэ үү? Манай улсаас тусласан бүх мөнгө нь 4189 алтан рублей, 31 хагас копек болно...» [ХУҮА. Ф. Р-112. Д. 1. ХН. 4] гэсэн 146 тоот бичгийг хүргүүлсэн байна. Насунов энэхүү бичгийг хүлээн аваад Халимагийн автономит мужийн төлөөлөгчид 1923 оны 10 сарын 26-д мэдэгдсэн [ХУҮА. Ф. Р-112. Д. 1. ХН. 4] байдаг. Халимагийн автономит мужийн төлөөлөгчийн газар энэ асуудлыг авч хэлэлцээд 1923 оны 12 сарын 1-ний өдөр № 1123 тоот бичгээр Москва дахь элчинд «Монголоос өлсгөлөн тохиолдсон Халимагуудад тусласан мөнгөний дүн нь: 1922 оны 6 сарын 6-д Монгол улсын бүх цэргийн штабын дарга Хувагаас нэг төгрөгний цагаан мөнгө зоосоор 2000 рублей, жижиг бутархай цагаан мөнгө 255, Хятад доллараар 3 янчан 50 мөнгө, зоос 1, Хятад улсын цаасан 10 копек, Зөвлөлт оросын 1921 онд хэвлэсэн цаасан 4000 рублын хамт хүлээн авсан бөгөөд 1922

оны 11-р сард Монгол улсад ЗОУ-ын элчин сайдын яамнаас мөн улсын гадаад хэргийн яамаар дамжуулан хүргүүлсэн 811 рубль, 37 копек ба цагаан мөнгөөр 154 фунт 28 /зол/ хүлээн авсанаас гадна, 1923 оны 6 сарын 6-нд ЗОУ-ын элчин сайдын яамнаас мөн улсын гадаад хэргийн яамаар хүргүүлсэн 220 алтан рублей, цагаан мөнгөөр 50 копек ба бас 1400 грамм задгай цагаан мөнгийг хүлээн авсан. Эдгээр мөнгийг Астарахань хотод буй Халимагийн өлсгөлөнд тохиолдсон ардууд тусламж үзүүлэх комиссд хүргүүлсэн бөгөөд гагцхүү 154 фунт, 28 /зол/ цагаан мөнгийг ЗОУ-ын улсын банкинд тушааж хадгалуулсан» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 46] хэмээн мэдэгдэжээ. Элчин сайдын яам энэ бичгийг 1923 оны 12 сарын 11-ны өдөр Монгол улсын гадаад хэргийн яаманд илгээсэн [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 48] байна.

МУ-аас Халимагт үзүүлж байсан энэхүү тусламжийг аваад өлсгөлөнгийн аюулыг гэтлэж чадаагүй тул Халимагийн өлсгөлөнд тусламж үзүүлэх комиссоос 5 хүн [Очиров 2010: 179] монголд очин дахин тусламж цуглуулахаар шийдсэнд Халимагийн засгийн газраас Оле Лиджиевич Рокчинский, Дандыр Бадушев-Баслиев, Эрдэни Эрендженев нарыг [Бадмаева 2010: 175] явуулахаар болж тэд 1922 оны 9 сарын 28-нд Москвад суугаа элчин сайдаас 41 тоот бичигт зөвшөөрөл авсан. Энэхүү комиссын дарга Бадушев-Баслиев 1922 оны 10 сарын 4-ний өдөр элчин сайд Даваад өргөдөл гарган «Алтан-булагаас Нийслэл хүрээ хүртэл өртөө улаа...» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 17] шийтгүүлэн Монголд ирсэн.

Тэрээр 1923 оны дундуур Халимагт буцаж ирсэн байдаг. Бадушев-Баслиевын Монголын засгийн газарт бичсэн өргөдөлд «Авч гарсан бага мөнгө дууссан тул замын зардалд 500 лан мөнгө олгоно уу? гэснийг засгийн газрын 1923 оны 1 сарын 25-ны өдрийн 60-р хурлын 7-р зүйлд хэлэлцээд ...Бадушев-Баслиев нь зөвхөн Халимагийн өлсгөлөнгийн хэргээр бус Орос сангийн худалдааны хэргийн хамтатган ирсэн тул туслах нь зүй бус» [МУЗГА. ЗГТ. 1922. Х. 39] хэмээн үзсэнээс харахад тэрээр Халимагийн өлсгөлөнд тусламж гуйхаас гадна Оросын худалдааны хэргийг хавсарч ирсэн аж. Халимагийн ардуудаас хувийн хэргээр хүмүүс ирж өлсгөлөнд ядарсан ардуудыг эмнэх, эмийн ургамал түүн авах [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194] зэргээр энгийн ардууд монголд цөөн бус ирж байв.

Бадушев-Баслиев нь Монголд ирээд «Монголын засгийн газраас олгосон 1500 лан болон 2000 рублийг аваад Халимагийн ард түмэн Монголын ах дүү нартаа маш их баярлаж байгаа, гэсэн хэдий ч өлсгөлөнгийн аюул өнгөрөөгүй тул олон түмэн ах дүүгээ үхэж, сөнөхийн аюулаас хэлтэрүүлмүй... манай мал урьд 1816200 байсан бол одоо 609291 болсон, Оросуудын тарьсан тариа энэ жил бага зэрэг ургасан, жаахан хоолтой байгаа харин малчин бид нар урьдын хэвээр өлсгөлөн байна. Хонь малгүй болсноор гэр хийх эсгий олодохгүй болж өлсгөлөн дээр амьдрах оронгүй болж байна» [МУТАХМАНБТ. Х. 4. Д. 1. ХН. 126] гэх зэргээр тухайн үеийн нөхцөл байдлыг өгүүлэн дахин тусламж олгоно уу? гэсэн № 76 тоот бичгийг 1922 оны 12 сарын 12-ны өдөр засгийн газар өргөн мэдүүлсэн ажээ. Энэ асуудлыг засгийн газрын 7-р хуралын 3-р зүйлд хэлэлцээд МАН-ын төв хороонд хүргүүлэн хэрхэн тусалваас зохих шийдвэр [МУТАХМАНБТ. Х. 4. Д. 1. ХН. 218] гаргуулахаар явуулжээ.

Намын төв хорооноос чиглэл болгосны дагуу энэ асуудлыг Засгийн газар 1923 оны 1 сарын 2-ны өдрийн 58-р хурлын 6-р зүйлд хэлэлцээд «Бидний ардын засгийн газар бол бүх Монгол овогтныг элбэрэх нигүүлсэхийг гол зорилгоо болгон эрмэлзэж, ...нэгэн үндэсний торгууд нар өлсгөлөнгийн зовлонд хэтэрхий нэрвэгдэн амьдрахад бэрхтэй болсоныг мэдсээр байж үл мэдэгчлэн өнгөрүүлж төвдөхгүй. Иймд манай Монгол нутаг уудам, газрын ашиг үлэмж тул эдгээр өлсгөлөнгийн газар буй Торгууд нарыг бүрэн нүүлгэн ирүүлж монголын харьяат болгон амьдрах аргыг бодож хүмүүжүүлэн тохинуулах нь зөв» [МУЗГА. ЗГТ. 1923. Х. 37] гэж үзээд энэ тухай «харьяат төлөөлөгчид Батушевт [Бадушев-Баслиев. — Н. Наранжаргал] мэдэгдэн Халимагын ардуудыг нүүхэд бэлтгүүлэх, гадаад явдлын яамнаас Оросын элчинд сайдад мэдэгдэх [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 105], мөн ардын засгийн газрын 5-н яам болон намын төв хороонд мэдэгдсэн» [МУТА. Х. 4. Д. 1. ХН. 218. Х. 11–17] байна. Гадаад яам энэ тухай 1923–1–23-ны өдөр ЗОУ-ын элчин сайдад № 461 тоот бичгээр мэдэгдсэн [МУТА. Х. 4. Д. 1. ХН. 218. Х. 5–10] байна.

Халимагийн төлөөлөгч Бадушев-Баслиев дээрхи бичгийг хүлээн аваад «... харьяат өлсгөлөнд тохиолдсон ардуудыг Монгол газар хэрхэн нүүлгэн ирүүлэх, хэрхэн хүмүүжүүлэхийг тогтоон

шийтгэмүй» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 81] хэмээн хариу ирүүлснийг Монгол улсын засгийн газрын 1924–3–1-ний өдрийн 1-р хурлын 5-рт хэлэлцээд «Нэг, Энэхүү Халимаг ардуудыг нүүлгэн ирүүлэхэд зүй нь харьяат Халимаг ардуудаас өөрсдөө комисс томилвоос зохих бөгөөд манай Монгол ардын засгийн газраас ЗОУ-д суугаа элчин сайдыг ойрхон байгааг үндэслэн Монголын талын төлөөлөгчөөр томилон харьяат комисст суулгая. Хоёр, Энэхүү Халимагуудыг нүүлгэн ирүүлж тэнхэрүүлэн хүмүүжүүлэх хэрэг маш хүнд, манай Монгол ардын засаг тусгаар тогтоож санхүүгийн хувьд ариажин хараахан чадаагүй байгаа тул замын хэрэглэлийг хараахан ганцаараа гаргаж дийлэхгүй. Зүй нь харьяат Халимагийн автономит мужийн төлөөлөгч ба ЗОУ, МУ-ын засгийн газар гурван этгээдээр зөвлөн хэлэлцэж хавсран гүйцэтгэвээс зохино. Гурав, Эдгээр халимаг ардуудыг нүүдлэн хүрч ирмэгц, харьяат олон аймгуудын дотор тэдний өөр өөрийн амьдран хүмүүжиж болох зохистой газар, тусгай нутаг заан олгож хуваан суулгамай. Дөрөв, Халимагуудад суух орон гэрийг манай засгаас бэлтгэн олгохоос гадна, бас өрх бүрт үнээ мал олгон тэжээн тэнхэрүүлэх явдлыг засгийн газраас хойш тушааж гүйцэтгэнэ» [МУЗГА. ЗГТ. 1924] хэмээн шийдээд ардын засгийн газрын 5 яам, намын төв хороо [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194], ЗОУ-ын элчин сайдын яам [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 81], ЗОУ-д суугаа элчин сайд [МУУТА. СнЗБ. Х. 1. Д. 6. ХН. 62], Халимагийн өлсгөлөнгийн төлөөлөгч [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 14] нарт тус тус мэдэгдэн явуулсан байна.

Халимагуудыг Монгол газар нүүлгэн ирүүлэх гэсэн энэхүү хэргийг «Өлсгөлөнгийн аюул, туйлын гачигдал өнгөрсөн» [МУЗГА. ЗГТ. 1924. Х. 2] хэмээн ЗОУ-ын талаас зөвшөөрөөгүй юм. Гэсэн хэдий ч тухайн үед Монгол ардын журамт цэрэгт алба хааж байсан Х. Б. Кануков «70 өрх торгуудыг Халимагийн Донский мужаас Ховдын хязгаарт нүүлгэн ирүүлж, цэргийн болон боловсронгуй ажил үүсгэх үүр байгуулах хийгээд гэгээн засгийн соёлд багтах хүсэлтэй... бидний нүүн ирэх асуудлыг шийдэж өгнө үү» [МУЗГА. ЗГТ. 1924. Х. 2] хэмээн «уг 70 өрх айлын дэлгэрэнгүй бүртгэлийн» [МУУТА. Х. 1. ХН. 29] хамт өргөсөннийг засгийн газрын 1924 оны 2 сарын 15-ны өдрийн 1-р хурлын 15-р зүйлд хэлэлцээд «...эдгээр 70 халимаг

өрхийг нүүн ирэхийг дэмжиж байгаа бөгөөд, хэрхэн нүүлгэн ирүүлэхийг урьд нэгэнт хэлэлцэн тогтсон журмын дагуу шийднэ”¹. Энэ асуудлыг хариуцан гүйцэтгэх комиссыг «Сангийн яамны сайд Дорж, хянан байцаах хэлтсийн дарга Цэдэн-Иш, гадаад, дотоод яамны эрхэлсэн түшмэл Довчин, Дэндэв, ардын намын төв хороо, Оросын элчин сайдын яам ба торгуудын төлөөлөгч нийж-гээдийг оруулж байгуулах»-ыг [МУЗГА. ЗГТ. 1924. Х. 2] тогтоосон ажээ. Энэ тухай гадаад яамнаас Оросын элчин сайдын яаманд 1924 оны 2 сарын 19-ний өдөр № 31 тоот бичгээр [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 12] мэдэгдэн явуулсанд элчин сайд Васильев «уг асуудлыг хэлэлцэх комисст зөвлөлт оросын элчин сайдын яамнаас А. П. Минкиныг томилсоныг» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 66. Н. 2] 1924 оны 2 сарын 22-ны өдөр № 269 тоот бичгээр мэдэгдэн ирүүлсэн. Энэхүү 70 өрх Халимагууд Монголд нүүн ирэх хэрэгт Монголын засгийн газар ихэд ач холбогдол өгч байсан бөгөөд уг комиссыг ажлаа тайлагнахыг удаа дараа шаардаж засгийн газрын хуралдаанаар уг комиссын шийдвэрийг хэлэлцэж байсан. 1924 оны 3 сарын 24-ний өдрийн засгийн газрын 5-р хурлын 3-р зүйлд энэ асуудлыг хэлэлцэхэд уул комиссоос мэдэгдсэн нь «Торгуудын төлөөлөгч нартай санал зөрөлдөж байгаа тул дахин сайтар зөвлөлдөөд засгийн газарт мэдэгдэ» ээ [МУЗГА. ЗГТ. 1924. Х. 4] илэрхийлсэн. Энэхүү комисс нь Халимагийн төлөөлөгч Халиновтой [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 13] удаа дараа санал зөрөлдсөнөө мэдэгдэхэд асуудлыг шуурхай шийдэх үүднээс уг комиссыг шинэчлэн байгуулж байв. Энэ бүхний эцэст засгийн газар удаа дараа байгуулагдсан комиссын шийдвэрүүдийг 1924 оны 3 сарын 28-ны өдрийн 7-р хурлын 5-рт хэлэлцээд нэгтгэн батлаж [МУЗГА. ЗГТ. 1924. Х. 6] ЗОУ-д явуулсан байдаг.

ЗОУ-ын тал эхэндээ энэхүү «70 өрх айлыг монгол руу нүүхийг зөвшөөрсөн» [МУГХЯА. Д. 2. ХН. 592]. Энэ үед ЗОУ нь МУ-д өөрийн олж авсан нөлөөгөө улам бэхжүүлэхийг эрмэлзэж байсан нь энэ шийдвэрийг гаргахад нөлөөлсөн бололтой. Энэхүү 70 өрхийн хүмүүс нь

¹ Монгол улсын засгийн газрын 1924-3-1 өдрийн 1-р хуралын 5-рт өлсөглөнгийн газар байгаа бүх халимагуудыг нүүлгэн ирүүлэх орос, халимаг, монгол гурван этгээд хамтран гүйцэтгэх бөгөөд хэрхэн нүүдлийг зохион байгуулах тухай 4 зүйлтэй журам гаргасан.

Х. Б. Кануковтай хамт Монголд ирсэн болон түүний удирлагад ажиллаж байсан ойр дотны нь хүмүүс байсан бөгөөд тэд Кануков болон ЗОУ-ын төлөөлөгчийн даалгавараар ихэвчлэн тагнуулын хэрэгт оролцож байсан байна. Энэхүү Халимагуудын амьдрах нөхцөл маш хүнд байсан бөгөөд Оросууд тэднийг огт хайхрахгүй байсанд тэд энэ тухайгаа асуудлаар удаа дараа зарга үүсгэж байсан. Ийнхүү Монгол дахь халимагууд асуудал гаргах болсоноор, ЗОУ-ын тал «энэхүү 70 өрхийн асуудал, Кануков болон түүний командын тухай нууц мэдээллүүдийг цуглуулж эхэлсэн» [МУГХЯА. Д. 2. ХН. 592] байна. Улмаар 1924 оны 6 сард Ховдоос Х. Б. Кануковыг Халимаг сургагч Цебилов, Налхаев, Морхадыков нарын хамт баривчлан Өргөөд хүргүүлсэн. Тэднийг Зөвлөлтийн сургагчийн амь насанд заналхийлсэн, цэргийн үүрэг гүйцэтгэхээс татгалзсан, Кануковыг Ховдын монголчуудын дунд хагалган бутаргах үндэсний үзэл гаргасан, Донын Халимагийн 70 цэргийн сургагчыг өрх бүлийн хамт нүүлгэн ирүүлж, учир битүүлэг дайнд бэлдэх гэх мэт хэд хэдэн үндэслэлээр буруутган [ХУУТА. Ф. Р-137. Оп. 1. Д. 2. Л. 40], 8 сард Монголоос гарган явуулсан. Ингэснээр энэхүү 70 өрх айлыг нүүх асуудал зогссон.

Монгол улсаас Халимагийн өлсгөлөнд тусласан тусламжийн зүйлүүд дотор тодорхой бус нэг зүйл байгаа нь 1000 шар үхрээр тусалсан хэрэг юм.

Энэхүү өлсгөлөнд тусласан малыг «ЗОУ-аас зээлдэн авсан мөнгөний төлбөрт өгсөн үхрийн хамт хилээр гаргасан» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 27] байна. Энэхүү «1000 шар үхрийг цэргийн хэрэглэлийн мал гаргаагүй баруун хоёр аймгаас гаргуулахаар 1922 оны 6-р сард шийдсэн» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 25] боловч «ирээгүй тул Засагт хан аймгийн бэйл Цэдэндорж, Далай гүний хоёр хошуунаас дараа жилийн татвараас урьдчилан 713 үхэр гаргуулан Мөрөнгийн хүрээний газарт ЗОУ-ын төлөөлөгчид хүлээлгэн өгөөд үлдсэн 287 үхрийг цаг оройтсон тул дараа жил нь өгөхөөр» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 29] болсон байна. 1923 оны 10 сарын 25-д өнгөрсөн жилийн 1000 шар үхрийг «Мөнөөх баруун хоёр аймгаас гаргуулан энэ оны 9-р сарын шинийн нэгэнд Мөрөнгийн хүрээнд хүргэн ирсэн» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 28] -ийг ЗОУ-ын элчинд мэдэгдэсэн байна. Энэхүү үхрийг хүлээн авах ЗОУ-ын төлөөлөгч болзсон газартаа

ирээгүй 1923 оны 11 сарын 29-нд сангийн яамнаас гадаад яаманд илгээсэн № 1145 тоот бичгээр «зохих газарт нь мэдэгдэнэ үү» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 31] хэмээн ирүүлснийг 1923 оны 12 сарын 4-ний өдөр №1089 тоот бичгээр [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 32] ЗОУ-д мэдэгдсэн. ЗОУ-ын тал эдгээрт хариу үл өгсөнд «энэхүү ЗОУ-ын өлсгөлөн ардуудад туслахаар илгээсэн малыг хүлээлгэн өгхөөр удаан хугацаанд хүлээж байгаагийн улмаас газар нутаг болон, эдийн засгийн хувьд хохирол хүлээж буй» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 34] 1923 оны 12 сарын 28-д № 1589 тоот бичгээр, мөн «энэ хүлээлтийн улмаас уг малаас хорогдол гарвал нөхөн олгохгүйг» [МУГХЯА. Х. 1. Д. 1. ХН. 194. Н. 33] 1923 оны 12 сарын 29-д № 1210 тоот бичгүүдээр удаа дараа сангийн яамнаас гадаад яаманд мэдэгдсэн байдаг.

Энэхүү 1000 шар үхэр хүлээн авсан тухай Халимагийн засгийн газрын албан ёсны хариу одоо хүртэл олдоогүй. Харин Монголын эрдэмтэн Д. Даш «Халимагийн ард түмэнд 1000 толгой шар бэлэглэсэн» [Даш 1979: 159], Халимагийн түүхч Ю. О. Оглаев «1923 оны 3 сар хүртэл монголоос 15000 лан мөнгө, 1000 толгой амбан шараар Халимагийн өлсгөлөнд тусласан» [Оглаев 1970: 23], Е. Н. Бадмаева «Ижил мөрний дагуух Оросын өлсгөлөнд нэрвэгдсэн ардуудад монголоос 1000 толгой мал өгсөн» [Бадмаева 2010: 176] гэх зэргээр тэмдэглэсэн бол, «Дальневосточный телеграф» сонины 1921 оны 9 сарын 16-ны өдрийн дугаарт «өлсгөлөнд нэрвэгдэгсдэд зориулж Монголын засгийн газар 1000 шар үхэр өгөв. Мөн бүх орон даяараа өглөг хуримтлуулахаар шийдвэрлэжээ» хэмээн мэдээлсэн байна.

Ийнхүү 1920 оны эхээр Ижил мөрний сав дагуух нутагт тохиолдсон өлсгөлөнгийн улмаас тухайн үеийн Халимагийн төлөөлөгч, монголд цэргийн алба хааж байсан сургагч нараас Богд хаан болон Монгол улсын засгийн газарт хандан тусламж гуйхад, ардын засгийн газар бүх

албан хаагчдын цалингаас 2 удаа хасан 1932 лан 50 пун хагас дээр засгийн хөрөнгөөс 2000 рубль нэмэн Халимагийн өлсгөлөнд тусламж цуглуулах Монголын комиссын дарга Ц.-Д. Номинхановоор дамжуулан Халимагийн засгийн гарт хүлээлгэн өгсөн нь тодорхой байна.

Мөн МУ-ын засгийн газраас Халимаг болон өлсгөлөн тохиолдсон Ижил мөрний сав дагуух Оросын харьяат ардуудад зориулан 1000 шар үхэр цуглуулж 1923 онд удаа дараа ЗОУ-ын талд хүлээлгэн өгсөн нь судлаачдын баримт, тухайн үеийн сонины мэдээ зэргээс тодорхой болж байна.

Энэхүү тусламжийг аваад Халимагийн өлсгөлөнд тусламж цуглуулах комиссоос өлсгөлөнгийн аюулыг гэтэлж чадаагүй улмаас дахин туслана уу хэмээхэд 1923–1–1-ний өдрийн 58-р хурлаар хэлэлцээд өлсгөлөнгийн газар буй үндэс угсаа нэгтэй Халимаг ахан дүүсийг Монгол газар бүрэн нүүлгэн ирүүлэх тухай тогтсонд ЗОУ-ын тал өлсгөлөнгийн аюул нэгэнт өнгөрсөн хэмээн нүүхийг зөвшөөрөөгүй тул Монгол газар цэргийн алба хашиж байсан сургагч Х. Б. Кануков Донын мужаас 70 өрх нүүлгэн ирүүлж Монгол улсын Ховдын хязгаарт суулган боловсронгуй ажил үүсгэн суухыг хүссэнд ЗОУ-ын элчин сайдын яамнаас анхандаа зөвшөөрч байсан боловч дахин шалган нягталж үзээд энэхүү Монголд ажиллаж буй Халимаг сургагч нар Зөвлөлт Оросын өгсөн хувьсгалт даалгаврыг үл гүйцэлдүүлэн, үндэс угсаа нэгт Монголчуудын эрх ашгийн төлөө ажиллах болсон хэмээн үзэж тус бүлгийн толгойлогч Х. Б. Кануков зэрэг хүмүүсийг баривчлан Монгол улсаас гаргасанаар Халимагуудыг Монгол улсад нүүх ирэхийг хориглож, тухайн үед Монголд ажиллаж байсан бүх Халимаг сургагч нарыг Монгол улсаас эргүүлэн татсан юм. Энэ нь тухайн үед монгол болоод халимагийн хоорондох харилцаа гүнзгийрч, монгол дахь оросын итгэл үнэмшил буурах болгоомжлол байсантай холбоотой.

Товчилсон үг (Сокращения)

МУГХЯА — Монгол улсын гадаад хэргийн яамны архив (Архив Министерства иностранных дел Монголии)

МУУТА — Монгол улсын үндэсний төв архив (Монгольский национальный центральный

архив)
МУУТАхМАНБТ — Монгол улсын үндэсний төв архивын харьяа Монгол ардын намын баримтын төв (Центр документов Монгольской народной партии Монгольского национального центрального архива)

МУЗГА — Монгол улсын засгийн газрын архив
(Архив Правительства Монголии)
ХУУТА — Халимаг улсын үндэсний төв
архив (Национальный архив Республики
Калмыкия)
СнЗБ — Сайд нарын зөвлөлийн баримт
(Документы Совета Министров)

ЗГТ — Засгийн газрын тогтоол (Постановления
Правительства)
Хн — Хадгаламжийн нэгж (Единица хранения)
Х — Хөмрөг (Фонд)
Д — Данс (Опись)
Н — Нугалбар (Лист)

**Ашигласан архивын эх сурвалж
(Архивные источники)**

Монгол улсын ГХЯ-ны архив — Архив
Министерства иностранных дел Монголии
Монгол улсын УТ Архив — Монгольский
национальный центральный архив
Монгол улсын ЗГ-ын архив — Архив
Правительства Монголии
Монгол улсын УТА-йн харьяа МАН-ын баримтын
төв — Центр документов Монгольской
народной партии Монгольского
национального центрального архива
Халимаг улсын УТАрхив — Национальный
архив Республики Калмыкия

Ашигласан ном (Литература)

Бадмаева Е. Н. Нижнее Поволжье: опыт и итоги
реализации государственной политики в
социально-экономической сфере (1921–
1933 гг.) / отв. ред. К. Н. Максимов. Элиста:
НПП «Джангар», 2010. 544 с.
Очиров У. Б. Вклад репрессированных народов
СССР в победу в Великой Отечественной
войне 1941–1945 гг. Том 1. Элиста: НПП
«Джангар», 2010. 575 с.
С интернациональной миссией: воспоминания
участников Монгольской народной револю-
ции / сост. Ю. О. Оглаев; под общ. ред.
И. Я. Златкина. Элиста: Калм. кн. изд-во,
1970. 143 с.
Даш Д. Халимагийн түүхэнд холбогдох хоёр
баримт // МАХН-ын түүхийн асуудал № 14.
Улаанбаатар, 1979.

Archive Sources

[The Archive of the Ministry of Foreign Affairs of
Mongolia]. (In Mong.)
[The Government Archive of Mongolia]. (In Mong.)
[The Mongolian National Central Archive]. (In
Mong.)
[The Mongolian People's Party Document Center
of the Mongolian National Central Archive].
(In Mong.)
[The National Archives of the Republic of
Kalmykia]. (In Russ.)

References

[On an International Mission: Memories of the
Participants of the Mongolian People's

Revolution]. Yu. O. Oglaev (compl.); I.
Ya. Zlatkin (ed.). Elista: Kalmyk Book Publ.,
1970. 143 p. (In Russ.)
Badmaeva E. N. [Lower Volga Region: Experience
and Results of Implementation of the State
Policy in the Social and Economic Sphere
(1921–1933)]. K. N. Maksimov (ed.). Elista:
Dzhangar, 2010. 544 p. (In Russ.)
Dash D. [Two Facts Related to the History of
Kalmykia]. In: [The History of the MPRP]. No.
14. Ulaanbaatar, 1979. (In Mong.)
Ochirov U. B. [Contribution of the Repressed
Peoples of the USSR to the Victory in the Great
Patriotic War of 1941–1945]. Vol. 1. Elista:
Dzhangar, 2010. 575 p. (In Russ.)